

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**I. ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ.**

Компани 2022 онд 14 төсөвт байгууллага, 97 аж ахуйн нэгж, 1157 айл өрх, нийт 1268 хэрэглэгчтэй дулааны эрчим хүч, цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулах гэрээ байгуулан ажилласан.

1. Дулааны эрчим хүч

Тайлант онд 39.08 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 38.2 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зуны улирал буюу 5 сарын 15-ны өдрөөс 9 сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд 1 зуух галлан орон сууцны хэрэглэгчдийг хэрэгцээний халуун усаар тасралтгүй ханган ажиллахаар төлөвлөсөн боловч 5 сарын 15-ны өдрөөс 6 сарын 30-ныг дуустал хугацаанд дулааны станц 0 зогсолт хийж зуухнуудад засвар хийж 7 дугаар сарын 1-ний өдрөөс 1 зуух галлан хэрэгцээний халуун усаар ханган ажилласантай холбоотойгоор дулаан үйлдвэрлэлийн төлөвлөгөө 2.3%-аар дутуу үйлдвэрлэсэн байна.

Сүлжээний нэмэлт усны зарцуулалт төлөвлөгөөнөөс 1.3 мян.м³-ээр буурч 22.1 мян.м³ гарсан байна. Усны алдагдалтай холбоотой дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан, шугам сүлжээнд гарсан гэмтлийг шуурхай устгаж, түгээх шугамын шинэчлэлийн ажлыг үе шаттай хийж байгаа зэргээс шалтгаалан нэмэлт усны алдагдал багассан. Мөн хуучин тосгоны 2 давхар байрууд нь хэрэгцээний халуун усны шугамгүй учир хэрэглэгчид сүлжээний усыг зүй бусаар ашиглаж нэмэлт усны зарцуулалтыг ихэсгэдэг байдалд хяналт тавьж хэрэглэгчдээр эргэлт, ухуулга сурталчилгаа хийх, системд тавьсан крантыг авч заглушка тавих зэрэг ажил зохион байгуулан ажилласан. Үүнтэй уялдан 22.1 тонн технологийн давс хэрэглэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 17.1 тонн давс хэрэглэж, 5.1 тонн давсыг хэмнэсэн буюу давсны хэрэглээ 22.6 хувиар буурсан байна.

2. Ус хангамж, ариутгал татуурга

315.3 мян.м³ ус олборлохоос 300.0 мян.м³ ус олборлон 95.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Тоолууржилт болон хэрэглэгчдийн усны зохистой хэрэглээтэй бий болж байгаагаас ус олборлолт буурсан.

Одоогийн байдлаар төсвийн байгууллага 100 хувь, бусад аж ахуй нэгж 100 хувь, айл өрхийн 93 хувь нь усны тоолуураар суурилуулан тооцоо хийж байна. 2022 онд 77 айл өрхөд 115 ширхэг, 9 ААНБ-д 8 ширхэг, нийт 123 тоолуур шинээр суурилуулсан.

277.3 мян.м³ бохир ус татан зайлуулахаас гүйцэтгэлээр 247.8 мян.м³ бохир усыг татан зайлуулсан.

Үндсэн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг мөн үетэй харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

№	Нэр	Хэмжих нэгж	2021 он	2022 он		Зөрүү	
			гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос	төлөвлөгөөнөөс
1	Үйлдвэрлэсэн ДЭХ	мян.Гкал	38.81	39.1	38.2	-0,6	-0.9
2	Дотоод хэрэглээ	мян.Гкал	3.2	3.2	3.2	-	-
3	Түгээсэн ДЭХ	мян.Гкал	35.61	35.9	35.0	-0.6	-0.9
4	Нүүрс	мян.тн	13.98	14,1	14,5	0.52	0.4
5	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/гкал	196.0	196.9	203.1	7.1	6.2
6	Нэмэлт ус	мян.тн	19.3	23.4	22.1	2.8	-1.3
7	Давс	мян.тн	17.8	22.1	17.0	-0.8	-5.1
8	Цэвэр ус	мян.тн	306.8	315.3	300.0	-6.8	-15.3
9	ЦЭХ-ний хэрэглээ	мян.кВт	2 266.1	2 352.3	2 226.5	-39.6	-125.8

Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд тайлант онд 2 352.3 мян.кВт цахилгаан эрчим хүч хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2 226.5 мян.кВт цахилгаан эрчим хүч хэрэглэн 125.8 мян.кВт буюу 5.3 хувиар цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарган ажилласан.

Сүлжээний усны насос, ус өргөх насосуудад давтамж хувьсгуур суурилуулснаар усны хэрэглээ, ачаалалд тохируулан ажиллагааны ашигтай горимыг тогтоон насосуудыг хувьсах горимоор ажиллуулах, мөн эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжөөр шинэчлэл хийж цахилгаан эрчим хүчний хэрэглээг өнгөрсөн оныхоос 39.6 мян.кВт-аар бууруулан ажиллаж байна.

Хэрэглэгчдээс нийт 1 303 дуудлага хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан. Засварын ажил үйлчилгээний орлого 9 748.9 мян төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Дуудлагыг төрлөөр нь ангилбал:


Дуудлагын төрөл	х.н	Халаалт	Хэрэгцээний халуун ус	Цэвэр ус	Бохир ус	Тоолуур	Бусад	Бүгд
2021 он	тоо	240	93	303	293	49	307	1 285
2022 он	тоо	177	120	310	249	132	315	1 303

II. САНХҮҮГИЙН ТАЛААР

Тайлант онд 3,537.4 сая төгрөгийн борлуулалт орлого хийхээр төлөвлөн 3,590.4 сая төгрөгөөр борлуулалт орлого хийж 101.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Эрчим хүчний алдагдлын татаас 545.4 сая төгрөгийн санхүүжилт авч, зардлыг 324.8 сая төгрөгөөр хэмнэн, 47.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж төлөвлөгөөт алдагдлыг 88.9 хувиар бууруулан ажилласан.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Нийт орлого	3,537.4	3,590.4	52.9	101.5
Үүнээс: Үндсэн үйл ажиллагаа	2,889.8	2,813.8	(75.9)	97.4
Үндсэн бус үйл ажиллагаа	102.2	231.1	128.9	226.2
Татаас санхүүжилт	545.4	545.4	0	100
Нийт зардал	3,962.2	3,637.4	(324.8)	91.8
Ашиг/алдагдал/	424.8	47.0	(377.8)	88.9
БО-ын 1 төгрөгт ногдох зардал	1.37	1.29	(0.08)	94.3

Санхүүгийн үзүүлэлтийг графикаар харуулбал:




Үндсэн үйлдвэрлэлээс 2 889.8 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр 2 813.8 сая төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын төлөвлөгөөг 97.4 хувиар биелүүлжээ.

Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын задаргаа.

Бүтээгдэхүүн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2022 оны	
			Төлөв-өөс	хувь
Цэвэр ус	181.1	195.6	14.5	108.0
Бохир ус	151.1	162.6	11.5	107.6
Хэрэгцээний халуун ус	150.6	121.7	28.9	80.8
Халаалт	2,406.9	2,333.9	(73.0)	97.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	2,889.7	2,813.8	(75.9)	97.4

Борлуулалтын төлөвлөгөөгөөр 181.1 сая төгрөгийн цэвэр ус борлуулахаас 195.6 сая төгрөг буюу 108.0 хувь, 151.1 сая төгрөгийн бохир ус татан зайлуулахаар төлөвлөснөөс 162.6 сая төгрөг буюу 107.6 хувь, 2,406.8 сая төгрөгийн дулааны эрчим хүчний борлуулалт хийхээс 2,333.9 сая төгрөг буюу 97.0 хувь, 150.6 сая төгрөгийн хэрэгцээний халуун усны борлуулалт төлөвлөснөөс 121.7 сая төгрөг буюу 80.8 хувь тус тус биелүүлжээ.

Борлуулалтад эзлэх хувийн жинг графикаар харуулав



Борлуулалт дутуу хийгдсэн шалтгаан:

Үндсэн үйл ажиллагааны борлуулалт төлөвлөгөөнөөс 75.9 сая төгрөгөөр дутуу орсон ба цэвэр бохир усны борлуулалт 54.9 сая төгрөгөөр давж дулааны эрчим хүчний борлуулалт 73.0 сая төгрөгөөр буурсан байгаа нь

- Гадна агаарын хэм өнгөрсөн үеийн мөн үеэс дулаан байснаас дулааны тоолууртай аж ахуйн нэгжүүд, төсвийн байгууллагуудын хэмнэлт, мөн 5 сарын 15-ны өдрөөс 6 сарын 30-ныг дуустал хугацаанд дулааны станц 0 зогсолт хийж зуухнуудад засвар хийж 7 дугаар сарын 1-ний өдрөөс 1 зуух галлан хэрэгцээний халуун усаар ханган ажилласантай холбоотой байна.

/ШГХК –ийн дулаан төлөвлөгөөнөөс 1455.3 гкалаар дутуу хэрэглэж 39.0 сая төгрөг/

Үндсэн бус үйл ажиллагаанаас 102.1 сая төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөж гүйцэтгэлээр 231.0 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлж 128.9 сая төгрөгөөр давуулсан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
Дулааны суурь хураамж	41.3	38.4	-2.9
Цэвэр, бохир усны суурь хураамж	43.6	44.8	1.2
Туслах аж ахуйн орлого	10.4	27.0	16.6
Засвар, ажил үйлчилгээ	6.8	47.4	40.6
Алдангийн орлого	0.0	73.4	73.4
Дүн	102.1	231.0	128.9

Засвар үйлчилгээний 47.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс 20.7 сая төгрөг нь Төсөвт байгууллагуудад хийсэн ажлын хөлс, 26.7 сая төгрөг нь засвар, ажил үйлчилгээ, бусад орлого байна.

Тайлант онд нийт 3,962.2 сая төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,637.4 сая төгрөгийн зардал гарч 324.81 сая төгрөг буюу 8.2 хувиар хэмнэлт гарган ажилласан. Нийт зардлын 37.0 хувийг цалин НДШ, 12.0 хувийг цахилгааны зардал, 18.1 хувийг нүүрсний зардал, 12.0 хувийг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, 1.6 хувийг хөдөлмөр хамгааллын зардал, 3.5 хувийг удирдлага ТУЗ-ийн зардал, 15.8 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Зардлын хэмнэлтийн талаар

Цалингийн зардал Жилийн дунджаар 14 орон тоог царцаан хавсран ажиллуулж хэмнэлт гарган ажилласан.

Цахилгааны зардал 41.5 сая төгрөгийн цахилгааны хэмнэлт гаргасан.

Албан томилолтын зардал 1.6 сая төгрөгийн томилолтын зардлыг зарцуулаагүй.

Хөдөлмөр хамгаалал 12.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Ковидын зардлын хэмнэлт, ажлын хувцасны үнийн дүнгийн зөрүүнээс хэмнэлт гарсан.

Бусдаар гүйцэтгүүлэх зардал 5.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Хэмнэлтийн хуулийн дагуу тэвчиж болох зардал болох даатгалын зардал 4.8 сая төгрөг, ажилчидын чөлөөт цагт зориулж төлөвлөсөн биеийн тамирын залны түрээсийн зардал 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулаагүй байна.

Туслах аж ахуйн зардал 3.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь 10 дугаар сараас малаа борлуулж цаашид туслах аж ахуйг эрхлэхгүй болсон.

Шатахууны зардал хэмнэгдсэн нь Удирдлага болон хэсэг нэгжийн дарга нарын Дархан-УБ -т томилолтоор ажиллахад зарцуулахаар төлөвлөсөн ,туслах аж ахуйд хэрэглэх, мөн сэлбэг материал татах зөөвөрлөхөд зарцуулахаар төлөвлөсөн зардлуудыг хэмнэж ажилласан

Зардлын гүйцэтгэл

№	Зардлын төрөл	12 сар		Өссөн дүн		Зөрүү	
		төлөв	гүйц	төлөв	гүйц		
1	Цалин	134,685.2	114,237.0	1,390,134.1	1,177,868.8	(212,265)	84.7
2	НДШимтгэл	19,529.4	16,564.4	201,569.4	169,776.5	(31,792.9)	84.2
	ДҮН	154,214.6	130,801.4	1,591,703.5	1,347,645.30	(244,058)	84.7
3	Урсгал засвар	552.3	7,068.3	54,203.4	52,314.3	(1,889.1)	96.5
4	Хангамжийн материал	1,850.0	4,469.1	14,255.1	14,058.7	(196.4)	98.6
5	Туслах материал	1,350.0	2,627.4	17,476.2	16,989.5	(486.7)	97.2
6	Цахилгаан эрчим хүч	64,454.6	69,220.1	480,570.4	439,063.4	(41,507.0)	91.4
7	Дотоод хэрэгцээ	21,154.3	21,154.3	159,135.4	158,371.9	(763.5)	99.5
8	Нүүрс	100,125.0	190,795.3	628,210.0	659,855.4	31,645.4	105.0
9	ТУЗ-ийн зардал	5,792.5	5,792.5	69,510.0	69,165.5	(344.5)	99.5
10	Холбоо	614.4	329.5	6,860.2	5,289.1	(1,571.1)	77.1
11	Бичиг хэрэг	904.0	180.7	4,628.0	3,579.1	(1,048.9)	77.3
12	Албан томилолт	1,070.5	644.0	6,280.5	4,583.8	(1,696.7)	73.0
13	ҮХ-н элэгдэл	36,419.0	36,419.0	437,527.8	437,503.9	(23.9)	100.0
14	Хөдөлмөр хамгаалал	2,559.5	5,642.5	69,791.4	56,820.0	(12,971.4)	81.4
15	Шатахуун түлш, тос	9,042.3	9,298.9	73,554.4	69,215.8	(4,338.6)	94.1
16	Дээж шинжилгээ	375.0	-	1,500.0	1,061.5	(438.5)	70.8
17	ҮХХ-н татвар	1,877.8	880.0	7,510.9	6,334.1	(1,176.8)	84.3
18	Газрын татвар	425.0	-	1,700.0	378.5	(1,321.5)	22.3
19	АТӨЯХ-н татвар	-	-	860.0	585.6	(274.4)	68.1

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

20	Усны нөөц ашиг.татвар	732.0	1,064.1	2,240.3	2,064.1	(176.2)	92.1
21	Бусдаар гүйц.ажил	3,922.2	4,647.3	61,102.6	55,234.8	(5,867.8)	90.4
22	Нийгэм САХэмжээ	27,270.0	400.0	55,050.0	86,245.7	31,195.7	156.7
23	Сургалт		1,990.0	4,465.6	4,251.6	(214.0)	95.2
25	Сэлбэг хэрэгсэл	1,093.0	4,495.8	19,798.8	17,239.3	(2,559.5)	87.1
26	Гүйцэтгэх удирдлагын зардал	8,394.7	8,394.7	99,097.0	58,884.9	(40,212.1)	59.4
27	Байгаль орчны нөлөөлөл	-	-	10,530.0	10,265.9	(264.1)	97.5
28	Усны зардал	4,768.0	4,768.0	33,525.0	32,939.4	(585.6)	98.3
29	Туслах аж ахуйн зардал	772.4		10,345.4	6,937.4	(3,408.0)	67.1
30	Бусад татвар			3,300.0	2,119.1	(1,180.9)	64.2
31	Ахмадын сан	-	-	9,900.0	8,180.0	(1,720.0)	82.6
32	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан			27,628.0	-	(27,628.0)	0.0
33	Үйл ажиллагааны бус бусад зардал				10,268.7	10,268.7	0.0
	Нийт зардлын дүн	449,733.1	511,082.9	3,962,259.9	3,637,446.3	(324,813.6)	91.8

- АВЛАГА

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31	өсөлт + бууралт -
Төсөв	72.0	0.9	-71.0
ААНБ	193.6	152.1	-41.5
Айл өрх	43.4	64.4	21.0
Засгийн газрын хөнгөлөлт	120.0	0.0	-120.0
Дүн	429.0	217.4	-211.5
Бусад авлага	4.7	6.3	1.6
НИЙТ ДҮН	433.7	223.7	-209.9

Оны эхнээс нийт авлага 209.9 сая төгрөгөөр буурсан байна.

- Төсвийн байгууллагуудын авлага 71.0 сая төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагуудын авлага 41.5 сая төгрөгөөр тус тус буурч, айл өрхийн авлага 21,0 сая төгрөгөөр өссөн байна. Өссөн шалтгаан нь 2020, 2021 онуудад Засгийн газрын хөнгөлөлттэй холбоотойгоор иргэд бэлэнчлэх сэтгэлгээнд сурч оны эхний 1-4 дүгээр саруудад 94.4 сая төгрөг хүртэл өссөн бөгөөд 5 дугаар сараас байцаагч нарт сар бүр барагдуулах авлагын төлөвлөгөө гарган өгч цалин урамшууллыг уялдуулсан журмыг

боловсруулан, үлдэгдэлтэй хэрэглэгч бүртэй төлөлтийн хуваарь гарган мөрдөн ажиллаж оны эцэст 30.0 сая төгрөгөөр бууруулан 64.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшингийн төлөвлөгөөнд нийт авлагыг 100.5 сая төгрөг байхаар төлөвлөсөн боловч нүүрсний үнийн зөрүүнээс үүссэн 177.9 сая төгрөгийн асуудлаар эвлэрлийн гэрээ байгуулж 2022-2024 онд халаалтын бус улиралд нийлүүлэх нүүрсний хэмжээгээр төлж барагдуулахаар хууль хяналтын байгууллагын шийдвэр гарснаар тайлант ондоо 61.8 сая төгрөгөөр буурч 123.2 сая төгрөгийн авлага бууруулах боломжгүй болсон.

- **ӨГЛӨГ**

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31	өсөлт + бууралт -
Цахилгаан	398.6	0.0	-398.6
Татвар	649.8	655.6	5.8
НДШ	422.3	431.2	8.9
Бусад өглөг	348.9	248.1	-100.8
ДҮН	1,819.6	1334.9	-484.7

Нийт өглөг

Нийт өр төлбөр оны эхнээс 484.7 сая төгрөгөөр буурсан байна.

- Татварын өглөг 5.8 сая төгрөг,
- НДШ-ийн өглөг 8.9 сая төгрөгөөр тус тус өсч
- Цахилгааны өр төлбөрийг тайлант онд 398.6 сая төгрөг төлж бүрэн барагдуулсан.
- бусад өглөг 100.8 сая төгрөгөөр буурсан байна.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээнд шаардагдах материалын тоо хэмжээг гаргахдаа агуулахад байгаа материалын үлдэгдлийг хасаж тооцон тухайн үеийн зах зээлд худалдан борлуулагдаж буй үнийг мөрдлөг болгон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төлөвлөж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дэмжүүлэн, гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/05 дугаар тушаалаар худалдан авах төлөвлөгөөг 26 багц бараа, ажил, үйлчилгээг нийт 437.7 сая төгрөгөөр худалдан авалт хийхээр баталсан.

185,3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 тендер шалгаруулалтыг онцгой журам буюу харьцуулалтын аргаар, 252,2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий шууд худалдан

авалт хийхээр анхны төлөвлөгөөг баталсан. Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/26 дугаар тушаалаар компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол оруулж 26 багц бараа, ажил, үйлчилгээг 391.4 сая төгрөгөөр худалдан авалт хийхээр батлуулсан.

Анхны батлагдсан төлөвлөгөөнөөс нийт 89.5 сая төгрөг хасч, 43.335 сая төгрөг нэмэхээр тодотгож, тодотгосон төлөвлөгөөгөөр 391.4 сая төгрөгөөр баталсан байна.

Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Босго үнэ”-ийг тодотгосон төлөвлөгөөнд мөрдлөг болгож худалдан авалт хийсэн.

Худалдан авалтыг цахимаар зохион байгуулж, үр дүнг нийтлэхээс гадна тендерийн урилгыг олон нийтийн хэвлэл болох “Зууны мэдээ” сонин, user.tender.gov.mn цахим хуудсаар зарлаж, худалдан авах ажиллагааны явц, гүйцэтгэлийн тайланг сар бүрийн 8-ны дотор шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн.

Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 337 дугаар тогтоолын 1.7-а-д заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үнэлгээний хороо байгуулсан тушаал, үнэлгээний хорооны гишүүдийн мэдэгдэл зэргийг тухай бүр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль"-ийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг баримтлан 47 дугаар зүйлд заасан шаардлагат нийцүүлэн 3 үнэлгээний хороог гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулж, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын хэрэгжилтийг ханган ажиллав.

Тайлант жилд зохион байгуулагдсан 3 тендерийг хуулийн хугацаанд нээж, нээлтийн 11 тэмдэглэлийг хэвлэн баталгаажуулсан. 2022 онд тендер шалгаруулалтаар 3 гэрээ байгуулан ажилласан. “Ус бэлтгэлийн дээврийн засварын ажил” тендерт Шүүдэргранд ХХК шалгарч гэрээ байгуулан ажилласан. Гэрээний дагуу дээрх ажлыг гүйцэтгэж, хүлээлгэн өгч 2022.08.16-ны өдөр актаар баталгаажуулсан байна. “Өрлөг дулаалгын материал худалдан авах” тендерт Баянбулаг ХХК шалгарч гэрээ байгуулан ажилласан. Гэрээний дагуу материал бүрэн нийлүүлж, 2022.10.03-нд гэрээ дүгнэж акт үйлдсэн байна. “Түлшшатахуун, тослох материал” нийлүүлэх тендерт хуулийн 30,4.3 дахь заалтыг үндэслэн “Халиун шарын гол” ХХК-тай 2022.09,08-нд №2022/27 дугаар шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж байна.

Тендер шалгаруулалттай холбоотой тендер оролцогчдоос ирүүлсэн гомдол, санал байхгүй, хуулийн дагуу зохион байгуулсан.

2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	ХАА-ны журмын хэлбэр	Худалдан авалтын тоо	сая.төг		Гүйцэтгэлийн хувь
			төлөв	гүйц	
1	Нээлттэй тендер шалгаруулалт	1	77.3	77.3	100
2	Харьцуулалтын арга	2	83.4	83.4	100
3	Зөвлөх үйлчилгээ	1	7.5	3.5	100
4	Шууд худалдан авалт	29	223.1	218.1	97.8
Дүн		33	391.3	382.3	97.7

III. ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЫН ТАЛААР.

Техник тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлийн ажлыг компанийн техникийн бодлогын баримт бичиг, техник тоног төхөөрөмжид хийсэн эрсдэлийн үнэлгээ, эрчим хүчний аудитын дүгнэлт, зөвлөмж зэргийг үндэслэл болгон үйлдвэрлэлийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, алдагдлыг бууруулах, үр ашигтай байх зорилтуудын хүрээнд үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн хэдийгээр өндөр байгаа ч хөрөнгө санхүүгийн боломжийг тооцоолон, хийгдэх ажлуудыг эрэмбэлэн зайлшгүй хийгдэх ажлуудыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 23 багц ажил хийхээр төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан. Үүнд:

- ✓ Зохион байгуулалтын талаар 8 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн
- ✓ Техник тоног, төхөөрөмж ашиглалт засварын талаар 10 багц ажил төлөвлөсөн, гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сургалтын талаар 5 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн байна.

ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Монгол Улсын Эрчим Хүчний сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/31дугаар тогтоолоор 2022 оны Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтаар 192.0 сая төгрөгийн 7 багц ажил хийгдэхээр төлөвлөгөөг батлуулсан.

Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх санал оруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Эрчим хүчний сайдын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн А/134 дугаар тогтоолоор 120.8 сая төгрөгийн 5 багц ажил хийхээр тодотгон батлуулж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа.

- Их засвараар 96.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ажил хийхээр төлөвлөн 100 хувь хийж гүйцэтгэсэн.
- Хөрөнгө оруулалтаар 3 төрлийн тоног төхөөрөмж авахаар төлөвлөн 100 хувь худалдан авалт хийгдэж, ашиглалтад оруулсан.

Нийт их засвар, хөрөнгө оруулалтын ажилд 118.4 сая төгрөг зарцуулсан байна.

УРСГАЛ ЗАСВАР:

Зуух, туслах тоноглол, шугам сүлжээний урсгал засвараар 21 багц ажил хийхээр төлөвлөж, 52.3 сая төгрөг зарцуулан 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Компанийн 2022 оны ИЗ, ХО-ын гүйцэтгэл

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төгрөг/	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Гүйцэтгэлийн хувь
1.Их засвар						
1	Зуух №2-ын халах гадаргуу өрлөг дулаалга, ул ширэмний засвар	багц	1	53,909.6	49,264.8	100%
2	Ус бэлтгэлийн барилгын дээвэр засвар	м2	750	42,907.8	42,888.6	100%
ДҮН				96,817.4	92,153.40	100%
2. Хөрөнгө оруулалтаар						
1	Цэвэр усны насос	ком	1	12,000.0	17,627.5	100%
2	Эргэлтийн усны насос /Grundfos/	ком	1	6,700.0	3,269.2	100%
3	Трансформатор 50 кВа 6/0.4	ш	1	5,300.0	5,300.0	100%
ДҮН				24,000.0	26,196.7	100%
НИЙТ ДҮН				120,817.4	118,350.10	100%

Засварын ажлын гүйцэтгэл, үр өгөөжийн талаар:

1. Зуух №2-ын халах гадаргуу өрлөг дулаалга, ул ширэмний засварын ажлыг өөрсдийн ажиллах хүчээр хийж бүрэн дуусгасан.



2. Ус бэлтгэлийн барилгын дээвэр засварын ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлан “Шүүдэр Гранд” ХХК шалгарч, гэрээ байгуулан бүрэн хийж дуусган хүлээлгэж өгсөн.



3. II-р өргөх станцад Д-320/50 маркийн насосыг эрчим хүчний хэмнэлттэй NIS100-65-250/55SW II маркын насосоор шинэчлэн, суурилуулж ашиглалтанд хүлээн авсан.



Өмнө ажиллаж байсан цэвэр усны насос Д-320/50



Шинээр суурилуулсан эрчим хүчний хэмнэлттэй цэвэр усны насос

4. Хэрэгцээний халуун ус хангамжийн тасралтгүй найдвартай ажиллагаа, чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор эргэлтийн усны насосыг шинээр худалдан авч суурилуулсан.



5. Эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу Цэвэрлэх байгууламжийн 250 кВа хүчин чадалтай трансформаторыг одоогийн хэрэглээнд тохирсон 50 кВа хүчин чадалтай трансформатораар шинэчлэн, суурилуулж ашиглалтанд хүлээн авсан.



6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан баг чиглэлийн ус, дулаан түгээх гол шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг “ЦАХИР ТҮМЭН АЛТАЙ” ХХК аймгийн засаг даргын тамгийн газартай гэрээ байгуулан тайлант онд ДХ32-оос ДХ42 худгийн хооронд 105 метр 5 хос шугамыг шинээр сольж ашиглалтанд оруулсан.

Хэрэгцээний халуун усны чанар сайжруулахаар орон сууцны 12 дугаар байрны буцахын шугамыг компани өөрийн хөрөнгөөр шинэчлэн сольж ажилд оруулсан. Эдгээр ажил хийгдсэнээр хэрэглээний халуун усны эргэлтийн шугам ажилд орж халуун усны чанар хүртээмж сайжирч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж дээшилсэн.

2022 онд ИЗ, ТЗБАХ, ХО-аар хийгдсэн ажлын үр өгөөжийн тооцоо

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	зарцуулсан хөрөнгө /мян.төг/	Төлөвлөгөөт ажлын үр дүн	Хэмнэлт /мян.төг/
1. ИХ ЗАСВАР				
1	Зуух №2-ын халах гадаргуу өрлөг дулаалга, ул ширэмийн засвар	49,264.8	Зуухны найдвартай ажиллагаа сайжирсан. Их засварын дараа техникийн магадлал усан шахалт, гадаад дотоод үзлэг, хамгаалах клапангийн туршилт хийж зуухны ашиглах зөвшөөрлийн 2026 он хүртэл 4 жилээр сунгуулсан.	-
2	Ус бэлтгэлийн барилгын дээвэр засвар	42,888.6	Барилгын дээврээс ус гоожих асуудал бүрэн зогсож ажлын байрны нөхцөл сайжирсан	-
ИХ ЗАСВАРЫН ДҮН		92,153.4		-
2.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
1	Цэвэр усны насос /NIS100-65-250/55SW II/	17,627.5	Ус өргөх II станцын Д-320-50 маркын 75 кВт-н хөдөлгүүртэй насосны хүчин чадлыг бууруулан одоогийн хэрэглээнд тохирсон NIS100-65-250/55SW II маркын эрчим хүчний хэмнэлттэй насос шинээр суурилуулж, ашиглалтанд оруулснаар ус хангамжийн үйл ажиллагааны найдвартай байдал сайжирсан. Мөн цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарган ажиллаж байна. Насосны цахилгааны эрчим хүчний хэмнэлтийг тооцоход хоногт. 360 кВт сард 10 800 кВт цахилгаан эрчим хүчний хэмнэлт гарсан. Мөнгөн дүнгээр тооцвол сард 2 276.5 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажиллаж байна.	9,106.0
2	Эргэлтийн усны насос /TD65-30G/	3,269.2	TD65-30G маркын эргэлтийн усны насос авч суурилуулснаар хэрэгцээний халуун усны хүртээмж, чанар сайжирч, усны зохистой хэрэглээ бий болсон. Хэрэглэгчдийн сэтгэл ханамж дээшилж ХХУ-тай холбоотой дуудлагын тоо буурсан.	-
3	Трансформатор /S11-M-50/6/ 50 кВа 6/0.4	5,300.0	Эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу цэвэрлэх байгууламжийн 250 кВа хүчин чадалтай трансформаторыг одоогийн хэрэглээнд тохирсон 50 кВа-н хүчин чадалтай эрчим хүчний хэмнэлттэй трансформатороор шинэчилж ашиглалтанд оруулсан. Ингэснээр трансформаторын хоосон явалт болон богино залгалтын алдагдал буурсан. Хоосон явалтын горимоор тооцоход сард 2160 кВт цахилгаан эрчим хүч буюу 455.3 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажиллаж байна.	2,731.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН		26,196.7		11,837.8
НИЙТ ДҮН		118,350.1		11,837.8

IV. ХАБЭА, АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТАЛААР ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР:

2022 онд ХАБЭА-н зардалд нийт 69791,4 сая төгрөг төлөвлөсөн. Зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал.

№	Зардлын нэр	Мөнгөн дүн	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	ХАБЭА-н хувцас, хамгаалах хэрэгсэл	46,903.2	42,304.3	4598.9	Үнийн зөрүү
2	Эрүүл мэндийн үзлэг	7,662.0	7,582.6	79.40	
4	ГАУС	8,176.2	5,685.2	2491	Бэлэн байдлын зардал
5	Эрсдэлээс хамгаалах зардал	6,635.0	860.0	5775.0	Нөхцөл байдал өөрчлөгдсөн
6	Эм, хэрэгсэл	415.0	387.9	27.10	
	Нийт дүн	69,791.4	56,820.0	2,971.4	

2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн

1. Ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.7 дугаар заалтад Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрх үүргийг тусгах ажлыг зохион байгуулсан.

2. Нийт ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд хяналт тавих, ХАБЭА-н эрх үүргийг тусгаагүй зөрчил байсанг ажлын байрны 4 дүгээр зорилтын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн заалтуудыг тусган өгч ажилласан.

3. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян”-ыг олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” уриан дор 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрүүдэд компанийн ХАБЭА зөвлөл, Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлсэн.

4. Компанийн хэмжээнд ХАБЭА –н 1, 2-р шатны үзлэгийн явцад тавих хяналтыг тухай бүр хийж гүйцэтгэсэн ба ХАБЭА-I шатны үзлэг нийт 000 удаа хийгдэж 158 зөрчил, ХАБЭА-II шатны үзлэг нийт 138 удаа хийгдэж 185 зөрчил илэрсэнг 100% арилгаж ажиллажээ.

ХАБЭА-III шатны үзлэг нийт 2 удаа хийгдсэн ба нийтдээ 79 зөрчил илэрсэнг арилгаж ажилласан.



5. Эрчим хүчний салбарт гарсан аваари ослын нийт 7 тохиолдлын сэрэмжлүүлэг мэдээлэл, албан даалгавар эрчим хүчний сайдаас ирсэнг компанийн хэмжээнд нэгдсэн төлөвлөгөө гарган ажилтнуудад сэрэмжлүүлэх ээлжит бус зааварчилгааг өгөх, дасгал сургуулилт явуулах, шаардлагатай заавар журмыг боловсруулах, эргүүл үзлэг шалгалт хийх зэргээр ажил зохион байгуулсан

6. Компанийн хэмжээнд аваари эсэргүүцэх дасгалыг “Шарын гол дэд станцын ЯЧ№6 МТО хамгаалалтаар тасрах үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Шарын гол РП-1 ЯЧ№9-ын кабель гэмтсэн үед аюч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг сэдвүүдээр төлөвлөгөөний дагуу дасгал сургуулилт хийж ажиллалаа.

7. Химийн бодисын зарцуулалт хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нийт химийн хорт болон аюултай бодисын зориулалтын сав баглаа боодол стандартын шаардлага хангасан байх тал дээр хяналт тавин агуулахын бүртгэлийн журналыг нээж, битүүмжилэн, агуулахад байршууллаа.

- ❖ Химийн бодис хадгалж байгаа агуулахын стандартыг хангах ажлын хүрээнд “Цэвэрлэх байгууламж болон Ус бэлтгэлийн химийн бодис хадгалах өрөө”-г камержуулан, хаалгануудыг дүрмийн дагуу лацдаж байх ажлыг зохион байгуулсан.

- ❖ Химийн бодисын зарцуулалт хадгалалтын байдалд байнгын хяналт шалгалт хийдэг боловч үр дүн муутай байсан асуудалд дүгнэлт хийж химийн бодисын зарцуулалт, агуулахын агааржуулалтын систем бүрэн бүтэн байдал, химийн бодисын сав баглаа боодол, аюулгүй байдалд дотоод хяналт тавин ажилласан.

- ❖ Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа химийн аюултай болон хортой бодисын хаягдлыг “Элемент” ХХК-д хүлээлгэн өгч нийт 130,67 кг.л химийн хортой болон аюултай бодис, 37 кг химийн бодисын хоосон савны хог хаягдлыг “Эм, халдвартай хог хаягдал болон химийн бодис /урвалж/” устгах комисс хүлээн авч

зориулалтын шатаах зууханд 1150°C -т бүрэн шатааж хаягдал үнсийг ландфиллдэж устгуулсан.



8. Сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран нийт ажилтнуудын дунд “Эрүүл амьдралын дадал зуршил” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтыг сумын дотрын эмч Т.Гэрэлмаатай хамтран зохион байгууллаа. Сургалтаар архидалт болон дам тамхидалтаас урьдчилан сэргийлэх, мөн зөв хооллолт, эрүүл амьдралын дадал зуршлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, санал солилцон үр дүнтэй сургалт боллоо. Сургалтад нийт 39 ажилтан хамрагдсан байна.



9. Ажилтнуудын эрүүл мэндийн хугацаат үзлэгийг ХАБЭМТ-ийн Мэргэжлийн өвчин судлалын газрын эмч, мэргэжилтнүүд нийт 76 ажилтанд хийж гүйцэтгэн, мэргэжлийн тохироо хийв. Нарийн мэргэжлийн эмч нар оношийн дагуу эмчилгээний заалт өгч, картанд тэмдэглэл хөтлөн эрүүл мэндийн заавар зөвлөмжүүдийг өгсөн болно. 76 ажилтанд. Ажилтнуудын дундах ердийн өвчлөл 80.2%, мэргэжлийн өвчлөл илэрсэн/-/, эрүүл ажилтан 19.8%-тайгаар тус тус гарлаа.



10. Эрүүл мэндийн үзлэгийн үр дүнтэй холбоотойгоор ажилтнуудыг эрүүлжүүлэн бялдаржуулах спортын арга хэмжээг шат дараалалтайгаар зохион байгуулан ажиллаж байна.



- Олон Улсын хөдөлмөрчдийн эвсанааны нэгдлийг өдрийг тохиолдуулан Дархан Уул аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн Холбооноос “Монголдоо ажиллаж, сайхан амьдаръя” уриан доор зохион байгуулагдсан “Эв санааны нэгдлийн бүх нийтийн кросс – 2022” уралдаанд компанийн ажилтнууд оролцож амжилт үзүүлсэн

- Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг алба, хэлтэс, хэсэг нэгжүүдийн хооронд байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт спортын тэмцээнийг амжилттай зохион байгуулсан нь ажилтнуудын эрүүл мэндийг дэмжсэн үр дүнтэй арга хэмжээ болсон



11. Ажлын байруудын орчны температур, агаарын чийгшилт, дуу чимээ, гэрэлтүүлгийн хэмжээг зориулалтын багажаар хэмжилт хийж, дүгнэлт гарган ажлын байрны нөхцлийг сайжруулах ажил зохион байгуулах ажлыг сар бүр хийж гүйцэтгэсэн


12. Компанийн нийт ажилтнуудын дунд “Амилуулах суурь тусламж” сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Сургалтыг сумын Эрүүл мэндийн төвийн мэс заслын эмч А.Бүркитхантай хамтран явууллаа. Сургалтанд нийт 31 ажилтан хамрагдсан



13. Ус түгээх худгуудад болон усны машины ёмкостыг улирал бүр ариутган ариутгалын дараа дотоодын шинжилгээг тухай бүр хийж стандартыг ханган ажилласан. МХГазрын лабораторит ундны усны эрүүл ахуйн шинжилгээг хийж, Геологийн төв лабораторид хүнд металлын шинжилгээг 1 удаа хийлгэх зэргээр ундны усны эрүүл ахуй аюудгүй байдалд хяналт тавин ажилласан.

БАЙГАЛЬ ОРЧИН

1. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлын гүйцэтгэл 90%.
2. Ундны усны эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг мэдээлэх самбаруудыг хийж трассын дагуу байршуулсан
3. Дархан Ус цаг уурын станцтай хамтран ажиллах гэрээ байгуулан үйлдвэрлэлийн орчны бүсэд болон БНС-н лаг хаягдалын талбайн ойр орчмын талбайд хөрс агаарын шинжилгээг төлөвлөгөөний дагуу хийлгэж хэрэгжилтийг ханган ажилласан



ГАЛЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тухай бүр тодотгол хийж ажилласан

2. Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах арга хэмжээнд тухай бүр бэлтгэл хангаж оролцсон.



3. Ажлын байр нэг бүрийн галын аюулгүй байдлын дотоод журам зааврийг шинэчлэн боловсруулж,галын гарцын схемүүдийг шинэчлэн боловсруулсан.

4. Сумын ОБ-н АГУ 55-р ангитай хамтарч байгууллагын хэмжээнд "Гал эсэргүүцэх дасгал"-ыг 2 удаа явуулсан.Үүнд

- Гал түймэр унтраах тархалтын сургуулилтыг 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Гал унтраах, аврах 55 дугаар ангитай хамтран танхим болон дадлага хэлбэрээр зохион байгуулсан



- Гал унтраах аврах 55 дугаар ангитай хамтран “Гал түймэр унтраах тактикийн дадлага сургалт”-ыг зохион байгуулсан. Сургалтанд нийт 23 ажилтан хамрагдаж, хэрхэн гал унтраах, осолд нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, бэлэн байдалд хэрхэн ажиллах зэрэг талаар дадлага сургуулилт хийж ажиллалаа.




5. Компанийн нийт ажлын байруудын галын булангийн иж бүрдэлтэнд хяналт тавьж нийт 4 тээврийн хэрэгсэлд галын хор байршуулах, нийт ажлын байрны 12ш галын буланд галын хөрөө 12,галын хөнжил 11,хүрз 12, хувин12, сүх 11, галын хорыг 2 удаа нийтдээ 85кг ийг шинээр цэнэглэсэн, галын автомат хор 11, цахилгаан байгууламжид ашиглах зориулалттай 3ш СО галын хорыг дулааны станцын ТП дотор байршуулах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.



6. Гамшгийн эрсдлийн үнэлгээг “ЕвроАзи сервис”ХХКомпаниар гүйцэтгүүлсэн ба гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллан, материалыг хүлээн авсан

7. Нийт ажилтнууд хавар намрын хуурайшилтын үед ГАУС-ын зааварчилгааг өгч ажилласан ба 2 удаа давхардсан тоогоор 120 ажилтан хамрагдсан.

Ой хээрийн түймрийн эргүүл үзлэгийг хийж суманд мэдээ өгч ажилласан



V. ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН ТАЛААР:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр тус компани зохион байгуулалтын 6 нэгжийн 44 албан тушаалд 102 ажилтан ажиллах ёстойгоос 42 албан тушаалд 88 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс 1 ажилтан нь хүүхэд асрах чөлөөтэй байгаа тул ажлын байрыг нь хэвээр хадгалж байна. Мөн түүнчлэн хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр 1 цахилгаанчин ажилладаг. ТУЗ-ийн хуралд танилцуулж алдагдалтай ажиллаж байгаа туслах аж ахуйг татан буулгасантай холбоотойгоор гэрээт малчны гэрээг 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс дуусгавар болгосон.

2022 онд шинээр 18 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж, 18 ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалсан байна. Үүнээс өөрийн хүсэлтээр 10, орон тооны цомхотголоор 1, өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор 3, сахилгын шийтгэлээр 4 ажилтан

хөдөлмөрийн гэрээгээ цуцалжээ. Сахилгын шийтгэлээр 15 ажилтан шийтгүүлснээс 1 ажилтны үндсэн цалинг 3 сар 20 хувиар, 2 ажилтан үндсэн цалинг 1 сар 20 хувиар, 12 ажилтныг сануулж шийтгэсэн байна. Ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор “Компанийн сарын үйл ажиллагааны үр дүнгээр шагналт цалин олгох журам”-ыг шинэчлэн батлуулж, “Ажилтанд чөлөө олгох журам”д нэмэлт өөрчлөлт оруулсан. Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн найруулсантай холбоотойгоор Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан.

Тайлант хугацаанд нийт ажилтнуудын хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийг тухай бүр хийж, шинээр орсон ажилтнуудыг програмд шивэх, баяжилт хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын хүний нөөцийг нөхөн бүрдүүлэх чиглэлээр нээлттэй ажлын байрны зарыг компанийн албан ёсны веб хуудас dshggov.com болон Дулаан шарын гол [facebook](https://www.facebook.com/dshggov) хуудсуудаар дамжуулан Шарын гол сумын хамгийн олон дагагчтай группүүдэд түгээж ажилласан. Нийт 10 ажлын байрны зар хүргүүлсэн.

Ажилтнуудын хөдөлмөр зүтгэлийг үнэлж Төрийн дээд Алтан гадас одонгоор 1, Эрчим хүчний салбарын тэргүүний ажилтнаар 6, Эрчим хүчний яамны жуух бичгээр 4, Санхүү банкны тэргүүний ажилтнаар 1, Сангийн яамны жуух бичгээр 1, Барилга хот байгуулалтын яамны жуух бичгээр 1, Дархан-Уул аймгийн тэргүүний ажилтнаар 5, Шарын гол сумын хөдөлмөрийн аварга ажилтнаар 1, Шарын гол сумын хүндэт тэмдгээр 3, Шарын гол сумын жуух бичгээр 4, Шарын гол сумын хүндэт өргөмжлөлөөр 6, Үйлдвэрчний эвлэлийн хорооны шагналаар 8, нийт 41 ажилтныг шагнаж урамшуулсан байна.

Тус компанид удирдах дээд байгууллага болон харилцагч байгууллагуудаас хугацаатай 158, хугацаагүй 222, нийт 380 баримт бичиг ирүүлснийг хүлээн авч бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн өгч шийдвэрлүүлж ажилласан.

Компанийн зүгээс бусад иргэн, хуулийн этгээд 381 албан бичгийг хүргүүлж ажилласан байна. Үүнд:

- ✓ Эрчим хүчний яаманд-90,
- ✓ Эрчим хүчний зохицуулах хороонд-11,
- ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт-21,
- ✓ Барилга, хот байгуулалтын яаманд-1,
- ✓ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд-7,
- ✓ Бусад иргэн, хуулийн этгээдэд-251.

Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтлөлтийг хийж ажилласан.

Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахын тулд 171 тушаалыг гүйцэтгэх захирлаас гаргаж ажилласан байна. Үүнээс үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 39 тушаал, хүний нөөцийн чиглэлээр 132 тушаал гарч, түүний хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

2022 онд хэрэглэгчдээс 23 өргөдөл, гомдол, санал ирүүлснээс 23 өргөдөл, гомдол, саналыг бүрэн шийдвэрлэсэн байна.

2022 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтуудад цахимаар болон танхимаар хамрагдлаа. 2022 онд төлбөртэй 9 сургалтад давхардсан тоогоор 49 ажилтан хамрагдаж 4,465.6 мянган төгрөг төлөвснөөс 4,251.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан.

Ажилтнуудыг чадавхжуулах сургалтын тоо, хамрагдсан ажилтнууд, зардал


№	Сургалтын гүйцэтгэл	Хамрагдсан ажилтны тоо	Дүн
1	Зуух, даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажиллах, эрх сунгах сургалт	29	1,990,000
2	Архивын ерөнхий газар зохион байгуулагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалт"	1	250,000
3	Эрчим хүчний яамнаас "ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль", "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-тай хамтран дулааны шугам сүлжээний гидравлик тооцоо боловсруулах, тохируулга зүгшрүүлэг хийх арга, аргачлалыг эзэмшүүлэх СЕРТИФИКАТ олгох сургалт	1	500,000
4	"Нарядын системийн мөрдөлт, Зохион байгуулалтын арга хэмжээ" сэдвээр сургалт	10	260,381
5	Монголын Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Холбоо ТББ-аас зохион байгуулагдсан "Хүний нөөцийн менежерийг чадавхжуулах" сургалт	2	1,047,600
6	Эрчим хүч хэмнэлтийн менежерүүдийг чадавхжуулах "Эрчим хүчний өгөгдөл мэдээлэл ба дүн шинжилгээ" сэдэвт сургалт	1	20,000
7	Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо мэргэжлийн ТББ-аас Дэлхийн ариун цэврийн байгууламжийн өдөрт зориулан "Нүхэн жорлонгийн шинэчлэл - инновацийн технологи" сэдэвт танхим болон цахим сургалт	3	20,000
8	Дархан-Уул аймагийн татварын хэлтсээс нягтлан бодогч нарын сургалт	1	13,636
9	МНААҮХ-оос зохион байгуулсан "Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн технологич инженерийг чадавхжуулах" сургалт	1	150,000
Нийт дүн		49	4,251,617

- Нийт ажилтны сургалтыг тухай бүр явуулсан ба үндсэн үйлдвэрлэлийн ажилтнуудад ААД болон ТАД-ийн сургалтуудыг classroom ашиглан хичээлүүдийг

байршуулан ажилласан. Тус цахим сургалтын дагуу ажилтнуудаас ААД-ийн ээлжит болон шалгалтыг авсан. ААД-ийн шалгалтыг нийт 56 ажилтан хамрагдахаас 100 хувь хамрагдсан ба 25 ажилтан хангалтгүй үнэлэгдсэн. Хангалтгүй үнэлгээ авсан ажилтнуудаас шалгалтын журмын дагуу 7-14 хоногийн хугацаа өгч, дахин шалгалт авсан ба шалгалт өгсөн ажилтнууд бүгд тэнцэж хангалттай үнэлгээ авсан. Давхардсан тоогоор 81 ажилтан хамрагдаж, хангалттай үнэлгээ өгсөн байна.

- Шинээр ажилд орсон ажилтнуудыг жинхлэх шалгалтад 8 ажилтан хамрагдаж хангалттай үнэлгээ аван үндсэн ажилтнаар томилогдсон.

Мэргэжлийн зэрэг ахиулах шалгалтын төлөвлөгөө гарган батлуулж, шалгалтын комиссын бүрэлдэхүүний хамт зэргийн шалгалтуудыг тухай бүр авсан. Зэргийн шалгалтад нийт 10 ажилтан хамрагдаж хангалттай үнэлгээ авч зэргээ ахиулсан.



Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний дагуу арга хэмжээ зохион байгуулж тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг хэрэглэгчдэд таниулах зорилгоор Хэрэглэгчээ сонсьё нээлттэй хаалганы өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан.



Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Тэрбум Мод” хөтөлбөрийн хүрээнд хавар, намар Мини-цогцолборт 18 буйлс, 112 хайлаас, нийт 130 мод тарив.



Аймгийн Засаг Даргын Тамгын газраас "Эрсдэлгүй хот" 14 хоногийн аян, “Шарилжгүй Дархан” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний, Засаг даргийн захирамжийн дагуу нийт 10 удаа хуваарьт нийтийн эзэмшлийн зам талбайн хог шороо, цас мөсийг цэвэрлэсэн.



VI.ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР :

2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр “Дотоод хяналтын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дотоод хяналт шалгалтыг 7 бүлэг, 37 чиглэлийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн. Дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх захирлын байгуулсан ажлын хэсэг болон дотоод хяналтын ажилтан хийж гүйцэтгэн үр дүнг тухай бүр гүйцэтгэх захиралд танилцуулан, захирлын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажилласан. Үүнд: Хууль тогтоомжууд болон компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд 4 чиглэлээр хяналт тавьж, 6 зөвлөмж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаанд 8 чиглэлээр хяналт тавьж, 3 зөвлөмж, санхүүгийн үйл ажиллагаанд 10 чиглэлээр хяналт тавьж, 10 зөвлөмж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд 10 чиглэлээр хяналт тавьж, 9 зөвлөмж, байгаль орчны нөхөн сэргээлтэнд 4 чиглэлээр хяналт тавьж 2 зөвлөмж, Бусад чиглэлээр 1 зөвлөмж, нийт 31 зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтлөж, мэдээлэлийн сан бүрдүүлэн ажилласан.